



“ЦЭСБ-АУДИТ” ХХК

Нягтлан бодох бүртгэл, хяналтын
итгэмжлэгдсэн хөндлөнгийн байгууллага

4256743, Дархан Уул аймаг, Дархан сум, 10-р баг
5-р хороо. “ЛХА” ХХК-ий 2 давхар 65 тоот

Утас/факс: 95112689, 89275858

Э-шуудан: tsesb.audit@gmail.com

2026.03.25 № 2/029
танай _____-ны № _____-т

Хараат бус аудиторын тайлан

ЗӨРЧИЛГҮЙ ДҮГНЭЛТ

Бид “Сор” ХК-ийн 2025 оны 12 дүгээр сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал тайлан, дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, тайлант жилийн эцсээрх мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, бусад тайлбар мэдээллийн хураангуйг багтаасан санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр тус компанийн санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу үнэн, зөв бодитой үзүүлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэлээ. Уг стандартуудыг дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу Компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

Санхүүгийн тайланд Удирдлага буюу Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх хариуцлага

Компанийн удирдлага нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу санхүүгийн тайлан бэлтгэх, үнэн зөв толилуулахтай холбоотой дотоодын хяналтыг боловсруулах, хэрэгжүүлэх хадгалах үүрэг хариуцлага хүлээх бөгөөд залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайланг бэлтгэхэд шаардлагатай нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгож, хэрэглэх, холбогдох асуудлыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй.

Засаглах эрх үүрэг бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хүлээнэ

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх Хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, аудиторын дүгнэлт бүхий тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилангаас эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан тайлангийн хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

Аудит нь санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаарх аудитын нотолгоо олж авахад гүйцэтгэх горимуудыг багтаадаг. Сонгож авсан горимууд нь аудиторын шийдлээс хамаарах бөгөөд залилан эсвэл алдаанаас үүдэлтэй санхүүгийн тайлангийн материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн үнэлгээ багтдаг. Эрсдэлийн энэхүү үнэлгээг хийхдээ аудитор нь байгууллагын дотоод хяналтын үр ашигт байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор бус тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимуудыг тодорхойлох зорилготойгоор байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж шударгаар толилуулахтай холбоотой дотоод хяналтыг авч үздэг. Мөн Удирдлагын хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлого болон тооцооллын зохистой байдлыг үнэлэх, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлэх ажил багтсан.

Бидний олж авсан аудитын нотлох баримтууд нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж бид итгэж байна.

ЗАХИРАЛ



Ч.ЦЭРЭННАДМИД

**"СОР" ХК-ИЙН 2025 ОНЫ 12 САРЫН 31-НЭЭРХИ
АУДИТЛАГДСАН ХУРААНГУЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН
БАЛАНС**

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,889,031.46	1,880,448.69
Татвар. НДШ-ийн авлага	47,251,751.99	42,757,445.38
Дансны болон бусад авлага		
Бараа материал		136,363.64
Бусад авлага	98,864,237.33	406,583,633.56
УГЗардал	27,381,118.00	60,264,582.42
Эргэлтийн хөрөнгийн дүн	175,386,138.78	511,622,473.69
Үндсэн хөрөнгө	826,508,627.17	795,474,929.09
Бие бус хөрөнгө	134,782.88	134,782.88
Бусад эргэлтийн бус хөрөнгө		-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	826,643,410.05	795,609,711.97
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,002,029,548.83	1,307,232,185.66
Дансны болон бусад өглөг	479,228,724.28	381,886,546.44
Цалингийн өглөг	3,111,467.38	897,723.58
Татварын өглөг	3,571,969.05	396,376,225.60
НДШ-ийн өглөг		273,200.00
Ноогдол ашгийн орлого	9,351,466.39	9,351,466.39
Урьдчилж орсон орлого	69,743.00	44,335,505.61
Бусад богино хугацаат өр төлбөр	602,429,071.37	602,429,071.37
Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,097,762,441.47	1,435,549,738.99
Урт хугацаат өглөг		
Урт хугацаат зээл		
Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	1,097,762,441.47	1,435,549,738.99
Хувийн өмч	87,887,966.00	87,887,966.00
Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг		-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэгдэл		-
Хуримтлагдсан ашиг, алдагдал	(183,620,858.64)	(216,205,519.33)
НИЙТ ӨМЧИЙН ДҮН	(95,732,892.64)	128,317,553.33
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН	1,002,029,548.83	1,307,232,185.66

Орлогын тайлан

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Үндсэн үйл ажилгааны орлого	383,386,923.66	369,977,334.58
ББӨ	277,935,788.13	313,552,202.77
Нийт орлого	105,451,135.53	56,425,131.81
Бусад орлого		
Борлуулалт, маркетингийн зардал		
Ерөнхий ба удирдлагын зардал	76,176,921.92	84,369,798.44
Бусад зардал	5,720,787.00	
Бусад ашиг/ алдагдал/		
Үндсэн үйл ажиллагааны үр дүн	23,553,426.61	(27,944,666.63)
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг, алдагдал		
Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал	23,553,426.61	(27,944,666.63)
Орлогын татварын зардал	2,927,421.36	



Татварын дараах цэвэр ашиг, алдагдал	20,626,005.25	(27,944,666.63)
--------------------------------------	---------------	-----------------

Өмчийн өөрчлөлтийн тайлан

ЭЗЭДИЙН ӨМЧ	Өмнөх он	Тайлант он
Эздийн өмчийн дүн	87,887,966.00	87,887,966.00
Эзэдийн өмсийн бусад хэсэг	-	-
Дахин үнэлгээний нөөц	-	-
Хуримтлагдсан ашиг. Алдагдал	(183,620,858.64)	(216,205,519.33)
НИЙТ ӨМЧИЙН ДҮН	(95,732,892.64)	- 128,317,553.33

Мөнгөн гүйлгээний тайлан

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	5,012,004.00	67,002,000.00
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	415,885,114.52	57,304,219.13
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(410,873,110.52)	9,697,780.87
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн орлого	409,139,504.07	
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн зарлага		
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	409,139,504.07	-
Санхүүжилтийн үйл ажиллагааны мөнгөн орлого	1,280,000.00	
Санхүүжилтийн үйл ажиллагааны мөнгөн зарлага	1,230,000.00	9,706,363.64
Санхүүжилтийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	50,000.00	(9,706,363.64)
Валютын ханшийн зөрүү		
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(1,683,606.45)	(8,582.77)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,572,637.91	1,889,031.46
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,889,031.46	1,880,448.69

